



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	20
5.2	Албан шаардлага	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
ҮОМШӨДС	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ
ТАНАА

2018.04.25 № 859
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийгмийн даатгалын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах асуудал нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 105,303.5 сая төгрөг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар албадан татан буулгасан Капитал банкинд байршиж байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3.3-д “нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих”, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.2-д “Тухайн банкны сүүлийн нэг жилийн санхүүгийн байдлын тайлан, орлого, үр дүнгийн тайланд шинжилгээ хийж, Монголбанкнаас тогтоосон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих, журам”-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтийг тогтмол хангасан байдлыг үндэслэх” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С БҮРЭНБАТ





2 Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч С.Чинзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй. Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 04 дүгээр сарын 05-наас 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1/925 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.



Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийгмийн даатгалын сангийн талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Нийгмийн даатгалын сан нь “даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ гэсэн эрхэм зорилготой ажилладаг бөгөөд 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалыг цогц үйлчилгээ бүхий даатгагч болох” гэсэн хэтийн зорилго тодорхойлон ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах,
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх,
- Доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих,
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Нийгмийн даатгалын сангийн удирдлага Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Тус сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Э-тайлан програм хангамж ашигласан байна.



Сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаартай "Бүтэц орон тоо батлах тухай" тушаалаар Дотоод аудит, мониторингийн газар 6 хүний орон тоотой байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. Тус газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 чиглэлийн ажлын хүрээнд дараах хяналт шалгалт хийж үр дүнг дүгнэж ажилласан байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянан баталгаажуулах явцад арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хяналт-шинжилгээ, үнэлгээг Нийслэлийн 6 дүүргийн харьяа хэлтсүүдэд болон Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын хэлтэст хийсэн,
- Нийгмийн даатгалын байгууллагуудын бүтэц, орон тоо, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал тооцож олгосон байдалд дотоод аудит хийж нийт 29.5 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн,
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 100 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ, 90 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ байна гэж дүгнэсэн,
- Хөндлөнгийн байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтын дүнгийн хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Нийгмийн даатгалын сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн аудитын 4 чиглэлд 5 эрсдэл тодорхойлж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны нийт зардал 2,134,263.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 21,342.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын зорилго учраас нийт зардлыг материаллаг байдлын сууриар сонгов.

Төлөвлөлтийн шатанд тухайн сангийн эрсдэлийг дунд гэж тооцож материаллаг байдлын хувийг 1 хувиар сонгосныг гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Албадан татан буулгасан Капитал банкинд хадгаламж болон харилцах данс байршиж байгаа нь эрсдэл гэж тооцож шинж чанарын хувьд материаллаг гэж үзсэн.



Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн тайланд харьяа 34 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	32	2	-	-
	Дүн	32	2	-	-

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитад хамрагдсан төсвийн шууд захирагчдын 32 санхүүгийн тайлангаас “Зөрчилгүй” 27 санал дүгнэлт авч, Нийслэлийн 9 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн 2018 оны санхүүгийн тайланд “Голден пейж аудит” ХХК нь гэрээгээр аудит хийснээс 5 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгснийг Үндэсний аудитын газрын Чанарын баталгаажуулалтын алба аудитын хангалттай хэмжээний, зохистой нотлох зүйлсийг бүрдүүлж санхүүгийн тайланд үндэслэлтэй дүгнэлт өгөөгүй гэж тогтоосон байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт алдаа зөрчлийн 28.9 хувь буюу 46,698.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 9.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65.3 хувь буюу 105,553.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 5.8 хувь буюу 9,432.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Тус сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 Алдаа зөрчил, түүний шийдвэрлэлт

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	92	8,477.0	9	9.0	8	250.0	75	8,218.0
2	ТЕЗ	5	106,518.1	-	-	1	105,303.5	4	1,214.6
	Дүн	97	114,995.1	9	9.0	9	105,553.5	80	9,432.6

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл



2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Нийгмийн даатгалын харьяа нийт 32 байгууллагуудын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах нийтлэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Цалин, үр дүнгийн урамшуулал, ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон,
- Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бөглөөгүй, шатахууны хэтрэлт хэмнэлтийн тооцоог нягтлан бодогч бодож баталгаажуулаагүй,
- Өмнөх онд өр төлбөрөөр бүртгээгүй томилолт, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын зардал олгосон,
- Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Санхүүгийн програм хангамж шаардлага хангахгүй,
- Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансны бичилт алдаатай хийсэн зэрэг нийт 8,477.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хугацаанд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Мэдээлэл технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийсэн бөгөөд материаллаг хэмжээний алдаа, зөрчил илрээгүй болно.

2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 20 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Санхүүгийн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 192.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдэл: Аудитын явцад залруулсан.

Асуудал 2: Мөнгөн хөрөнгө

Санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 948,531.3 сая төгрөг тайлагнаснаас Капитал банкин дахь үлдэгдэл нийт мөнгөн хөрөнгийн 11.1 хувь буюу 105,303.5 сая төгрөг байна.

Шийдэл: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дараах анхаарал татахуйц асуудлыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:



- Нийгмийн даатгалын сангийн Капитал банкттай 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан МХ18-07/1-70 дугаартай 2,400.0 сая төгрөгийн Мөнгөн хадгаламжийн гэрээний биелэлт болон харилцах дансууд дахь мөнгөн хөрөнгийн буцаан төвлөрүүлэлт,
- Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Монголбанкны ерөнхийлөгч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хамтарсан 2018 оны 204/208/A210 дугаартай шийдвэрээр Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгөөс 2018 онд арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 600,000.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу тайлант оны эцсийн байдлаар арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршиж байгаа 439,335.0 сая төгрөгийн мөнгөн хадгаламжийн гэрээний биелэлтийг хянаж үзэх.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар төвлөрүүлэх орлогын хэмжээг 1,911,227.3 сая төгрөг, зарцуулах төсвийг 1,808,255.2 сая төгрөгөөр баталжээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант онд 2,090,066.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 178,839.6 сая төгрөгөөр давуулсан боловч зардлын гүйцэтгэл 1,814,624.4 сая төгрөг буюу батлагдсан төсвийг 6,369.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Хүснэгт 3 Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсөв, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт эх үүсвэр	1,911,227.30	2,090,066.90	178,839.60
Нийт зарлага	1,808,255.20	1,814,624.40	6,369.20
Үүнээс:			
Тэтгэврийн даатгалын сан	1,619,655.60	1,619,326.60	(329.00)
Тэтгэмжийн даатгалын сан	102,430.80	112,143.90	9,713.10
ҮОМШӨ-ий даатгалын сан	31,705.90	29,936.20	(1,769.70)
Ажилгүйдлийн даатгалын сан	35,437.80	34,357.30	(1,080.50)
Үйл ажиллагааны зардал	19,025.20	18,860.40	(164.80)

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дээрх хүснэгтэд харуулсан тэтгэмжийн даатгалын сангийн зардал батлагдсан төсвөөс 9,713.1 сая төгрөгөөр хэтэрсэн нь Нийслэлийн дүүргүүдийн тэтгэмжийн сангийн зардал 6,836.9 сая төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын сангийн удирдлага нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын 2018 оны ажлын тайланд дурдсанаар шилэн дансны цахим хуудсанд 35 салбар эрх, 238 хэрэглэгчээр хандаж Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагааны нийт 7513 мэдээнээс хуулийн дагуу 6650 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.



Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2018 оны байдлаар 94.0 хувьтай, 1 албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн өр төлбөр барагдуулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй бөгөөд үйл ажиллагааны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх онтой харьцуулахад 453.4 сая төгрөгөөр өссөн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргасан бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

Аудитын гол асуудлыг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө

3.1.1 Илрүүлэлт

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг зөвхөн НДЕГ-ын хэмжээнд жил бүр 86.3 сая төгрөгөөр төсөвлөдөг боловч аймаг нийслэлийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн туслах үйл ажиллагааны орлого өмнөх онд 246.8 сая төгрөг, тайлант онд 485.5 сая төгрөг төвлөрсөнөөс 317.1 сая төгрөгийг давсан орлогоор тооцож зарцуулсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийг бодитой төсөвлөхгүй байх, давсан орлогыг зөрүүтэй тооцох

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д төсвийн зарчмыг мөрдлөг болгох гэсэн шаардлагыг баримталж төсвийн төслийг боловсруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Ажиллагсадтай холбоотой өр төлбөр

3.2.1 Илрүүлэлт

Нийгмийн даатгалын байгууллагуудын нийт өр төлбөрийн 87.0 хувь буюу 483.8 сая төгрөг нь ажиллагсадтай холбоотой өр төлбөр байна. Үүнд, НДШ-ийн өр 459.7 сая төгрөгөөр, ХХОАТ-ын өр 24.1 сая төгрөгөөр өмнөх оноос тус тус өссөн байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийг бодитой төсөвлөхгүй байх, авлага, өр төлбөр үүсэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:



Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д төсвийн зарчмыг мөрдлөг болгох гэсэн шаардлагыг баримталж төсвийн төслийг боловсруулах, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Урьдчилан сэргийлэх зардал

3.3.1 Илрүүлэлт

НДЕГ-ын даргын 2018 оны А/96 дугаар тушаалд заасны дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд зохион байгуулсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх 310.0 сая төгрөгийн сургалтын ажлын тайланг нэгтгэн дүгнээгүй, зардлын гүйцэтгэл гаргаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 Хөрөнгийн бүртгэл, тайлагнал

3.4.1 Илрүүлэлт

Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын тасгийн конторын барилгын эскиз зургийн төлбөр 21.6 сая төгрөгийг санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд 2016 оноос бүртгэж ирсэн нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг алдаатай бүртгэх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,291,314,055.6	1,076,245,831.6
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,097,677,977.9	948,531,340.6
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	57,000,000.0	0.0
АВЛАГА	134,990,085.3	126,488,810.3
УРЬДЧИЛГАА	445,962.1	850.5
БАРАА МАТЕРИАЛ	1,200,030.4	1,073,930.2
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		150,900.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	38,846,004.3	37,146,118.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,846,004.3	37,146,118.4
Биет хөрөнгө	38,611,837.4	35,623,323.7
Биет бус хөрөнгө	234,166.9	1,522,794.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,330,160,060.0	1,113,391,950.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,939,118.6	22,701,357.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,939,118.6	22,701,357.0
Өглөг	3,777,691.2	13,815,808.6
Урьдчилж орсон орлого	6,161,427.4	8,885,548.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,320,220,941.4	1,090,690,593.1
Засгийн газрын хувь оролцоо	1,320,220,941.4	1,090,690,593.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,153,958.6	12,209,752.7
Хуримтлагдсан үр дүн	1,306,046,084.0	1,074,061,072.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,020,898.7	4,419,767.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,330,160,060.0	1,113,391,950.1

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,815,975,691.2	2,378,432,134.1
ТАТВАРЫН ОРЛОГО	1,439,650,402.9	1,699,186,192.9
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,439,650,402.9	1,699,186,192.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,516,591.8	79,531,027.5
Нийтлэг татварын бус орлого	111,666,229.1	78,555,955.4
Тусламжийн орлого	850,362.7	975,072.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,263,808,696.5	599,714,913.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,580,710,585.8	2,128,400,859.7
УРСГАЛ ЗАРДАЛ	3,580,710,585.8	2,128,400,859.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,348,966.5	22,287,086.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,574,308.1	13,895,288.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,602,084.8	1,654,588.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,115,629.4	941,406.5
Хангамж, бараа материалын зардал	470,796.8	494,372.9
Эд хогшил, урсгал засварын зардал	64,712.2	173,761.3
Томилолт, зочны зардал	126,578.0	138,237.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,549,752.1	2,229,737.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,845,105.0	2,759,693.3
ТАТААС	38,114,976.1	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,520,246,643.2	2,106,113,773.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	235,265,105.4	250,031,274.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,381,232.5	509,708.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,377,995.7	5,862,742.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	235,268,342.2	244,678,240.4

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,805,671,939.9	2,409,733,383.8
ТАТВАРЫН ОРЛОГО	1,432,240,077.8	1,692,302,468.0
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,432,240,077.8	1,692,302,468.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,677,220.0	107,386,975.5
Нийтлэг татварын бус орлого	115,677,220.0	107,386,975.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,257,754,642.1	610,043,940.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,581,278,596.6	2,558,834,599.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,581,278,596.6	2,558,834,599.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,389,044.8	20,222,369.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,005,467.0	13,483,500.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,652,202.8	1,571,785.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,052,771.6	942,220.9
Хангамж, бараа материалын зардал	425,382.5	465,655.3
Эд хогшил, урсгал засварын зардал	65,576.6	83,016.1
Томилолт, зочны зардал	126,578.0	138,711.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,803,279.2	3,209,737.0
Бараа үйлчилгээний бусад зардал	257,787.1	327,742.4
ТАТААС	37,737,855.3	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,522,151,696.5	2,538,612,230.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	224,393,343.3	-149,101,216.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.0	39,455.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	39,455.8
Дотоод эх үүсвэрээр	0.0	39,455.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.0	-39,455.8
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-800.7	-5,965.5
Бусад эх үүсвэр	1,802.8	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,603.5	5,965.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	224,392,542.6	-149,146,637.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	873,285,435.3	1,097,677,977.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,097,677,977.9	948,531,340.6



4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,084,248,137.3	0.0	1,084,248,137.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	751,554.8	0.0	751,554.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,084,999,692.1	0.0	1,084,999,692.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-47,093.0		-47,093.0
Тайлант үеийн үр дүн	235,268,342.2	0.0	235,268,342.2
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,320,220,941.4	0.0	1,320,220,941.4
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,320,220,941.4	0.0	1,320,220,941.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-476,663,252.0	0.0	-476,663,252.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	843,557,689.4	0.0	843,557,689.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,398,869.1	0.0	1,398,869.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,055,794.1		1,055,794.1
Тайлант үеийн үр дүн	244,678,240.4	0.0	244,678,240.4
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,090,690,593.1	0.0	1,090,690,593.1

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		1,097,677,977.9		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,808,255,215.2	1,814,624,408.7	-6,369,193.5	98.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,808,255,215.2	1,814,624,408.7	-6,369,193.5	98.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,781,423.0	18,390,138.7	391,284.3	98.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,347,160.8	13,313,122.3	34,038.5	100
Үндсэн цалин	9,691,583.2	10,092,250.6	-400,667.4	107
Нэмэгдэл	2,274,082.9	1,873,171.4	400,911.5	84.5
Унаа хоолны хөнгөлөлт	658,988.6	645,316.7	13,671.9	88.8
Гэрээт ажлын хөлс	722,506.1	702,383.6	20,122.5	97.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,570,582.7	1,562,820.3	7,762.4	99.8
Тэтгэврийн даатгал	1,051,161.6	1,046,175.1	4,986.5	110.6
Тэтгэмжийн даатгал	129,855.0	129,236.5	618.5	79.1
ҮОМШӨ-ний даатгал	103,884.4	103,299.0	585.4	80.2
Ажилгүйдлийн даатгал	25,971.0	25,787.1	183.9	81.2
Эрүүл мэндийн даатгал	259,710.7	258,322.6	1,388.1	75.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,032,908.7	985,880.2	47,028.5	99.7
Гэрэл, цахилгаан	239,945.4	218,600.9	21,344.5	108.2
Түлш, халаалт	594,030.8	579,821.9	14,208.9	96.9
Цэвэр, бохир ус	78,908.9	68,837.6	10,071.3	95.8
Байрны түрээс	120,023.6	118,619.8	1,403.8	112.3
Хангамж, бараа материалын зардал	466,207.1	464,770.5	1,436.6	100
Бичиг хэрэг	140,128.6	140,406.5	-277.9	86.3
Тээвэр, шатахуун	142,213.3	140,859.7	1,353.6	104.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	113,614.0	114,167.6	-553.6	99.5
Ном, хэвлэл	0.0	0.0	0.0	112.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,821.9	6,765.1	1,056.8	84.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	62,429.3	62,571.6	-142.3	127.7
Нормативт зардал	0.0	0.0	0.0	100
Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	0.0	0.0	100
Эд хогшил, урсгал засварын зардал	64,317.3	63,931.4	385.9	100
Багаж, техник, хэрэгсэл	26,686.4	26,458.8	227.6	93.2
Тавилга	0.0	0.0	0.0	100
Урсгал засвар	37,630.9	37,472.6	158.3	102.8
Томилолт, зочны зардал	131,456.6	128,423.0	3,033.6	99.7
Гадаад албан томилолт	0.0	0.0	0.0	135.8



Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дотоод албан томилолт	131,456.6	128,423.0	3,033.6	84.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	0.0	0.0	101.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,908,790.1	1,712,561.4	196,228.7	52.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,042,695.8	902,266.6	140,429.2	46.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	47,913.1	46,906.1	1,007.0	100
Даатгалын үйлчилгээ	29,956.8	29,312.5	644.3	100
Тээврийн хэрэгслийн татвар	6,312.1	5,103.2	1,208.9	99
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.0	0.0	96.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	431,576.1	431,095.2	480.9	100
Газрын төлбөр	11,105.5	9,117.9	1,987.6	98.7
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	240,230.7	189,759.9	50,470.8	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	99,000.0	99,000.0	0.0	
Бараа үйлчилгээний бусад зардал	259,999.7	158,629.6	101,370.1	100
Бараа үйлчилгээний бусад зардал	96,000.0	0.0	96,000.0	100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	163,999.7	158,629.6	5,370.1	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,789,473,792.2	1,796,234,270.0	-6,760,477.8	100
Бусад урсгал шилжүүлэг	1,789,473,792.2	1,796,234,270.0	-6,760,477.8	100
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,788,824,482.1	1,795,589,152.1	-6,764,670.0	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	248,865.4	244,673.2	4,192.2	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	376,057.0	376,057.0	0.0	100
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,387.7	24,387.7	0.0	100
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0	0.0	99.7
Барилга байгууламж	0.0	0.0	0.0	100
Их засвар	0.0	0.0	0.0	99.1
Тоног төхөөрөмж	0.0	0.0	0.0	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,808,255,215.2	2,090,066,920.0	-	98.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	609,817,672.0	609,817,672.0	0.0	99.9
Улсын төсвөөс санхүүжих	609,817,672.0	609,817,672.0	0.0	99.9
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,198,351,208.8	1,477,346,490.2	-	99.9
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,198,351,208.8	1,477,346,490.2	-	99.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	86,334.4	2,902,757.8	-2,816,423.4	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	2,510,962.7	-2,510,962.7	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,334.4	391,795.1	-305,460.7	



Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,906.0	2,924.0	-18.0	100
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		-424,591,313.3		
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		948,529,175.9		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	41.0	41.0	0.0	100
Төсвийн байгууллага	34.0	34.0	0.0	100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,436.0	1,445.0	-9.0	100
Удирдах ажилтан	42.0	42.0	0.0	100
Гүйцэтгэх ажилтан	1,216.0	1,228.0	-12.0	100
Үйлчлэх ажилтан	64.0	68.0	-4.0	100
Гэрээт ажилтан	114.0	107.0	7.0	100



5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	
2019/04/23		Аудитын код:	САГ-2019/31/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		<i>Нийгмийн даатгалын сан</i>	сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ						
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН						
1	Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 105,303.5 сая төгрөг Капитал банкинд байршиж байна.	105,303.5	Албан шаардлага	2019.04.22	НДЕГ-ын дарга СБГ-ын дарга	Д.Зоригт Б.Даваахүү
2	Туслах үйл ажиллагааны орлого дутуу төсөвлөсөн.	399.2	Зөвлөмж	2019.04.22	НДЕГ-ын дарга БХСГ-ын дарга	Д.Зоригт Ц.Ганцэцэг
3	Ажиллагсадтай холбоотой өр төлбөр нэмэгдсэн.	483.8	Зөвлөмж	2019.04.22	БХСГ-ын дарга СБГ-ын дарга	Ц.Ганцэцэг Б.Даваахүү
4	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтын ажлын тайланг нэгтгэн дүгнээгүй, зардлын гүйцэтгэл гаргаагүй байна.	310.0	Зөвлөмж	2019.04.22	БХСГ-ын дарга СБГ-ын дарга	Ц.Ганцэцэг Б.Даваахүү
5	Дуусаагүй барилга дансанд хөрөнгө оруулалтын зардал 2016 оноос бүртгэлтэй байна.	21.6	Зөвлөмж	2019.04.22	СБГ-ын дарга Ахлах нягтлан бодогч	Б.Даваахүү Ц.Эрдэнэтуяа
Нийт		106,518.1				
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ						
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР						
1	Барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй автомашины 1 граж олон жилийн өмнө зарагдаж өөр эзэмшигчтэй болсон боловч байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй байна.	4.4	Албан шаардлага	2019.02.22	НДЕГ-ын дарга Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адьяасүрэн
2	ХХОАТ-ын тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй, тайлант хугацаанд илүү төлөлт хийж авлага үүссэн.	2.2	Зөвлөмж	2019.02.22	НДЕГ-ын дарга	Д.Зоригт П.Адьяасүрэн



Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

					Ахлах нягтлан бодогч	
3	Санхүүгийн програм хангамж нь нягтлан бодох бүртгэлийн шаардлагыг бүрэн хангахгүй байна.	-	Зөвлөмж	2019.02.22	НДЕГ-ын дарга Ахлах нягтлан бодогч	Д.Зоригт П.Адьяасүрэн
	Нийт	6.6				



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 дугаар сарын 25

№ 05/237

Улаанбаатар хот

САГ-2019/31/СТЭ-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 105,303.5 сая төгрөг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар албадан татан буулгасан Капитал банкинд байршиж байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3.3-д "нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих", Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.2-д "Тухайн банкны сүүлийн нэг жилийн санхүүгийн байдлын тайлан, орлого, үр дүнгийн тайланд шинжилгээ хийж, Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих, журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтийг тогтмол хангасан байдлыг үндэслэх" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..." Монгол Улсын ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөх журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын сангийн Капитал банктай 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан МХ18-07/1-70 дугаартай 2,400.0 сая төгрөгийн Мөнгөн хадгаламжийн гэрээний биелэлтийг дүгнэж, харилцах данснууд дахь 102,903.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.
2. Биелэлтийн талаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нарт хариуцуулав.

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Ж.БОЛОРМАА
АУДИТОР
Э.ЭНХБААТАР

**АЛБАН ШААРДЛАГЫГ
ЗӨВШӨӨРСӨН:**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА
Д.ЗОРИГТ
САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ДАВААХҮҮ

Акт, албан шаардлагын биелэлт хансагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тоогуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.